

**ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 6 сарын 18 өдөр

№ 1126/2024

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, 34.2, Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5, Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг үндэслэн нэг талаас 5164753 регистрийн дугаартай "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ, түүнийг төлөөлж Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтсийн дарга Э.Хангал /цаашид "Зохион байгуулагч"/ гэх, нөгөө талаас Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж "Гипотенуз дизайн" ХХК, түүнийг төлөөлж Б.Ариунзаяа /цаашид "Зураг төсөл зохиогч" гэх, /хамтад нь "талууд" гэх/ нар дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Зохион байгуулагч нь барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж, Зураг төсөл зохиогч нь магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг хангаж, магадлалын ажлын хөлсийг төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Талууд хамтын ажиллагаандаа тэгш эрхийн зарчмыг баримтлах бөгөөд шударгаар хамтран ажиллаж, бие биеийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих үндсэн дээр харилцана.
- 1.3. Зураг төсөл зохиогч нь дараах ерөнхий мэдээллийг үнэн зөв бөглөнө. Үүнд:

Захиалагч /Хөрөнгө оруулагч/:

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

Зураг төслийн гүйцэтгэгч:

"Гипотенуз дизайн" ХХК

Барилга байгууламжийн байршил:

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо

Барилга байгууламжийн нэр:

Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/

Магадлалын ажлын төлбөр:

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт

/Жишиг үнээр/

692,730 /төг/

Архив №:

ГД:26-2023/05

ХОЁР. МАГАДЛАЛЫН АЖЛЫН ТӨЛБӨР

2.1. Зохион байгуулагч холбогдох норм дүрмийн дагуу үнэ бодолт хийж, магадлалын ажлын төлбөрийг тооцно.

2.1.1. Зураг төсөл зохиогч магадлалын ажлын төлбөр 692,730 /зургаан зуун ерэн хоёр мянга долоон зуун гучин / төгрөгийг Зохион байгуулагч байгууллагын Голомт банкны 1175107789 дугаар дансанд энэхүү гэрээний 2.1-д заасан үнэ бодолтыг хийлгэсэн өдөрт багтаан шилжүүлнэ.

2.1.2 Зураг төсөл зохиогч зураг төсөл, хайгуул, судалгааны ажлын үнийн дүнгийн 0.18 хувиар нормчлолын сангийн төлбөрийг тооцож Зохион байгуулагч байгууллагын Худалдаа хөгжлийн банкны 2600078533 дугаар дансанд шилжүүлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажсан өдрөөс хойш хуанлийн 21 өдрийн дотор хүчин төгөлдөр үйлчилнэ.

3.2. Зохион байгуулагч шаардлагатай тохиолдолд гэрээг сунгах болсон шалтгаан нөхцөлийг тодорхой дурдаж, гэрээний хугацааг хуанлийн 21 хүртэл хоногоор нэг удаа сунгах бөгөөд энэ тохиолдолд хугацаа сунгасан нэмэлт гэрээ байгуулна.

3.3. Энэхүү гэрээний 5.1.1-д заасан нөхцөл байдал үүсч, экспертний дахин томилсон тохиолдолд хугацаа алдсан хоногийг гэрээний нийт хугацаанд нэмж тооцно.

3.4. Талууд гэрээг цуцалснаар, эсвэл гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр, гэрээний хугацаа дууссанаар талуудын гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг дуусгавар болно.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Зохион байгуулагч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

4.1.1. "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ажлын зураг төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас"-ны дагуу Зураг төсөл зохиогчоос магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг гаргуулах;

4.1.2. Эксперт зураг төслийн баримт бичгийг хянаж, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн тохиолдолд зураг төсөл зохиогчоос засвар өөрчлөлтийг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэхийг шаардах;

4.1.3. Магадлал хийлгэхэд шаардагдах зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл хангагдаагүй тохиолдолд магадлал хийлгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;

4.1.4. Зураг төслийн баримт бичгийн иж бүрдэлд тусгагдаагүй боловч магадлал хийх ажлыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай баримт материалыг зураг төсөл зохиогчоос шаардах;

4.1.5. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх экспертний зураг төслийн цахим системээс санамсаргүй түүврийн аргаар томилох;

4.1.6. Эксперт томилсон томилгооны хуудсыг зураг төсөл зохиогчид хүлээлгэн өгөх;

4.1.7. Томилогдсон эксперттэй холбогдож, зураг төсөлд магадлал хийхээр томилогдсон тухай нэн даруй мэдэгдэх;

4.1.8. Эксперт хүндэтгэн үзэх шалтгааны улмаас магадлал хийх боломжгүй болсон тухайгаа мэдэгдсэн тохиолдолд өөр экспертээр солих;

4.1.9. Экспертний гаргасан магадлалын дүгнэлтэд техникийн шинжтэй алдаа /үг үсэг, нэршил, байршил... г/ м/ гарсан тохиолдолд зураг төсөл зохиогчийн санаачилгаар нягтлан үзэж залруулга хийж ажиллана.

ТАВ. ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зураг төсөл зохиогч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:
 5.1.1. Эксперт зураг төсөлд магадлал хийхээр томилогдсон өдрөөс хойш ажлын 2 хоногийн хугацаанд утсаа аваагүй, утас нь холбогдох боломжгүй байсан бол дахин эксперт томилуулах хүсэлт гаргах;
 5.1.2. "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ажлын зураг төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас"-ны дагуу магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг хангах;
 5.1.3. Зураг төслийн баримт бичгийн иж бүрдэлд тусгагдаагүй боловч магадлал хийх ажлыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай баримт материалыг гаргаж өгөх;
 5.1.4. Эксперт зураг төслийн баримт бичгийг хянаж, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн тохиолдолд засвар өөрчлөлтийг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх;
 5.1.5. Зохион байгуулагчид гаргаж өгсөн баримт материалын үнэн зөвийг хариуцах;
 5.1.6. Зураг төслийн цахим мэдээллийн санд нэвтэрч, өөрийн байгуулсан гэрээт ажлын явцад өдөр тутмын хяналт хэрэгжүүлэх;
 5.1.7. Гэрээний хугацаанд гэрээний нөхцөл бүрэн биелэгдэх боломжгүй болсон тохиолдолд шалтгаан, тайлбарыг тодорхой дурдаж хугацаа сунгуулах тухай албан бичгээр хандах;
 5.1.8. Эксперт зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, эсвэл магадлалын дүгнэлт гаргасны дараа зайлшгүй шалтгааны улмаас өөр экспертээр сольсон тохиолдолд анх үзсэн экспертийн цалинд тооцох хөлсийг зохион байгуулагчид үл маргах журмаар төлнө. /магадлалын ажлын төлбөр дээр нэмж тооцно/

ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

6.1. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр, гэрээний хугацаа дууссанаар талуудын гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг дуусгавар болно. /гэрээ дуусгавар болно/
 6.2. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 6.2.1. Талууд харилцан тохиролцооноор гэрээг хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.
 6.2.2. Гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцална. Энэ тохиолдолд мөн гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.
 6.2.2.1. Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд;
 6.2.2.2. Гэрээний аль нэг тал итгэл эвдэж, төөрөгдөлд оруулсан нь нөгөө талын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд;
 6.3. Зураг төсөл зохиогч энэхүү гэрээний 5.1.4-т заасан үүргээ удаа дараа /2 ба түүнээс дээш/ биелүүлээгүй тохиолдолд зохион байгуулагч байгууллагын санаачилгаар гэрээг цуцална.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
 7.2. Гэрээ дуусгавар болох, цуцлахтай холбогдон гарсан үр дагавар /магадлалын ажлын төлбөр/-ыг талууд дараах байдлаар зохицуулна. Үүнд:
 7.2.1. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдээгүй байхад гэрээний хугацаа дуусч /цаашид сунгагдахгүй болсон/, гэрээ дуусгавар болсон тохиолдолд магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, дүгнэлт гаргасан экспертүүдийн цалинд тооцох хөлс болон зохион байгуулагч талын хөлсийг буцаан олгохгүй. Харин магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянаагүй, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгөөгүй, дүгнэлт гаргаагүй экспертүүдийн цалинд тооцох хөлсийг зураг төсөл зохиогчид буцаан олгоно.
 7.2.2. Энэхүү гэрээний 6.2.1-д зааснаар талууд харилцан тохиролцож, гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох тохиолдолд энэхүү гэрээний 7.2.1-д заасан зарчмыг баримтална.
 7.2.3. Зураг төсөл зохиогчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг хугацааны өмнө цуцлах тохиолдолд магадлалын ажлын төлбөрийг буцаан олгохгүй.
 7.2.4. Зохион байгуулагчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг хугацааны өмнө цуцлах тохиолдолд магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, дүгнэлт гаргасан экспертүүдийн цалинд тооцох хөлсийг хэвээр үлдээн, үлдэх төлбөрийг зураг төсөл зохиогчид буцаан олгоно.

НАЙМ. БУСАД

8.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
 8.2. Гэрээг хугацааны өмнө цуцлах саналаа нөгөө талдаа ажлын 5 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор хариу ирүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
 ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
 ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
 ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
 ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

О.БАДАМХОРОЛ

Чингэлтэй дүүрэг, Их тойруу 1,
 "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ
 Утас: 7011-5255

Захиалагчийг төлөөлж:

"ГИПОТЕНУЗ ДИЗАЙН" ХХК-ЫН
 АРХИТЕКТОР

Б.АРИУНЗАЯА

Захиалагчийн утас:70171239
 Гүйцэтгэгчийн утас:88031083

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТИЙН НЭГТГЭЛ

2024 оны 07 дугаар сарын 18

Дугаар 1306/2024

Улаанбаатар хот

Барилга, байгууламжийн байршил:	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороо
Барилга, байгууламжийн нэр, зориулалт:	79, 90 дүгээр цэцэрлэг орчимд хийх "Гудамж, зам талбайн тохижилт"-ын ажлын зураг төсөл, төсөв
Зураг төслийн шифр:	ГД:26-2024/05
Хүчин чадал:	Тохижилтын ажил
Захиалагч:	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Санхүүжилтийн үүсвэр:	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Гипотенуз дизайн" ХХК
Регистрийн дугаар:	6701477
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2026-11-15
Ажлын төрөл:	ЗТ-2.1, ЗТ-8.1, ЗТ-10.2 заалтуудын дагуу
Зураг төсөл боловсруулах даалгавар баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Нийлэлийн Ерөнхий архитекторын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталсан МЗХ2024/00-163 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон "Гипотенуз дизайн" ХХК-ийн захирал нарын хооронд 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан СХД/2024/ЗҮ-24 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл:

Зураг төслийн бүрдэл:	Зураг төсөл		Магадлал хийсэн экспертний нэр
	Гүйцэтгэсэн байгууллага:	Шалгасан архитектор, инженер	
Ерөнхий төлөвлөгөө:	"Гипотенуз дизайн" ХХК	Б.Анхбаяр	С.Түмэн-Өлзий
Төсөв:	"Гипотенуз дизайн" ХХК	Г.Удвал /Мэргэшсэн төсөвчин/	Д.Оюунцэцэг

Зураг төсөлд магадлал хийсэн экспертүүдээс зөвшөөрсөн 2, татгалзсан эксперт байхгүй байна.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 79, 90 дүгээр цэцэрлэг орчимд хийгдэх "Гудамж, зам талбайн тохижилт"-ын ажлын зураг төсөл, төсөв				
№	Тодорхойлолт	Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал /м²/	Нэгж өртөг /төг/
1	а/. Гадна тохижилтын ажил:			
ГТ	Автомашин зогсоол хийх	234,772,780	2000.23	117,373
	Ногоон байгууламжийн ажил	38,662,200	417.8	92,538
	Явган зам талбай хийх ажил	138,822,655	1221.87	113,615
	Бетон талбай хийх ажил	26,431,463	233.7	113,100
	Хэсгийн дүн:	438,689,098		
2	б/. Гэрэлтүүлгийн ажил			
ТТ	1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч/нарны энергийн эх	94,122,601	35	2,689,217
	Хэсгийн дүн:	94,122,601		
1	в/. Зураг төслийн ажил:			
ТТ	Зураг төслийн үнэ	19,050,000	-	-
	Хэсгийн дүн:	19,050,000	-	-
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо				
1	Тохижилтын ажил	438,689,098		
2	Гэрэлтүүлгийн ажил	94,122,601		
3	Зураг төслийн ажил	19,050,000		
	Нийт төсөвт өртөг:	551,861,699		

Төсөвт өртөг:	Эксперт нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 79, 90 дүгээр цэцэрлэг орчимд хийх “Гудамж, зам талбайн тохижилт”-ын ажлын төсөвт өртгийг 551,861,699.0 /таван зуун тавин нэгэн сая найман зуун жаран нэгэн мянга зургаан зуун ерэн есөн/ төгрөгөөр хянасан байна.
---------------	---

“Барилгын тухай” Монгол улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т “барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 38.1.3-т “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 39.4-т “Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.”, 39.5-д “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ”.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 79, 90 дүгээр цэцэрлэг орчимд хийх “Гудамж, зам талбайн тохижилт”-ын ажлын зураг төсөл, төсөвт “Барилгын тухай хууль”-ийн 34.1.4, 34.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 51 дүгээр тогтоол, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэн бүртгэлийн дугаар олгов.

Дүгнэлтийн нэгтгэл нь экспертүүдийн **3** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Ц.АМАРСАНАА

Д.АЛТАНХУЯГ

Э.ХАНГАЛ


П.МӨНГӨНТУУЛ

Г.САНСАР

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /**Ерөнхий төлөвлөгөө**:/
Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/

2024 оны 06 сарын 24 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо
3	Зураг төслийн байгууллага	"Гипотенуз дизайн" ХХК
4	Зургийн шифр	ГД26-2024/05
5	Хуудасны тоо	ЕТ-10 хуудас
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Нийслэлийн ерөнхий архитектор баталсан 2024 оны 04 сарын 01-ны өдрийн МЗХ2024/00-163 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаварын дагуу боловсруулжээ. Загвар зураг ирүүлээгүй.
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Захиалагч байгуулагатай зөвшөөрөлцсөн
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	-----
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Одоо байгаа барилгуудын дунд авто ба явган хүний зам, ногоон байгууламж төлөвлөсөн байна
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	-----
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	-----
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	Тусгааргүй
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	-----
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	Зураг төслийг холбогдох норм дүрмийн дагуу боловсруулсан байна. Дараах зургуудыг нэмж тусгах .Үүнд. <ul style="list-style-type: none"> Батлагдсан зургийн даалгаварт тусгагдсан гэрэлтүүлэгийн байгуулалт, ус зайлуулах суваг, хог хаягдалын төвлөрүүлж, тээвэрлэх, зөөвөрлөх цэгийн схем зэргийг зурагт үзүүлэх Төлөвлөж байгаа явган хүний замд сандал, сүүдрэвч, хогийг сав тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний зам зэргийг тусгах.
Дүгнэлт бичсэн Эксперт № 1-18 С.Түмэн-Өлзий /...../		
 2024 оны 06 сарын 24 өдөр		

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/

2024 оны 06 сарын 24 өдөр

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	Зургийн даалгавар ирүүлээгүй тул шалгах боломжгүй байна. Зургийн даалгавар ирүүлэх	Архитектур төлөвлөлтийн даалгавар болон батлагдсан эскиз зургийг файлаар явуулав.
2	<p>Зураг төслийг холбогдох норм дүрмийн дагуу боловсруулсан байна. Дараах зургуудыг нэмж тусгах .Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> Батлагдсан зургийн даалгаварт тусгагдсан гэрэлтүүлэгийн байгуулалт , ус зайлуулах суваг, хог хаягдалын төвлөрүүлж , тээвэрлэх , зөөвөрлөх цэгийн схем зэргийг зурагт үзүүлэх Төлөвлөж байгаа явган хүний замд сандал, сүүдрэвч, хогийг сав тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний зам зэргийг тусгах. 	<p>- Гэрэлтүүлгийн байгуулалтыг нэмж зурав - Гадаргын ус зайлуулалтыг зам талбайн өндөржилтөөр шийдэв. - Хог хаягдал төвлөрүүлэх, тээвэрлэх зөөвөрлөх цэг, сандал, сүүдрэвч, хогийн савыг захиалагчын хүсэлтээр төлөвлөөгүй болно. - Явган замын хэсэглэл хэсэг дээр хөтөч хавтангийн байрлалыг тусгасан болно.</p>
<p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 1-18 <i>С.Түмэн-Өлзий</i> /С.Түмэн-Өлзий/</p> <p>2024 оны 07 сарын 01 өдөр</p> <p>Биелэлтийн тайлбар бичсэн <i>Б.Ариунзаяа</i></p> <p>2024 оны 06 сарын 26 өдөр</p>		

Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /Барилгын төсөв:/
Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/

2024 оны 07 сарын 01 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо
3	Зураг төслийн байгууллага	"Гипотенуз дизайн" ХХК
4	Зургийн шифр	ГД:26-2024/05, төсөв ТШ-71/2024
5	Хуудасны тоо	ЕТ-10, төсөв -14 хуудас
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	Мэргэшсэн төсөвчин Г.Удвал гүйцэтгэсэн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороо гудамж, зам талбайн тохижилт /79, 90-р цэцэрлэг орчимд/ төсвийг хянан магадлаад дараах шүүмж зөвөлгөөг өгч байна
Дүгнэлт бичсэн Эксперт № 9-44		Д.Оюунцэцэг /  2024 оны 07 сарын 01 өдөр

2024 оны 07 сарын 01 өдөр




Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2


ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

Гудамж, талбайн тохижилт /79,90-р цэцэрлэг орчимд/

2024 оны 07 сарын 01 өдөр

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	Материалын үнийг нягтлах. Үүнд:-1м явган замын хашлага 1ш хашлагын үнээр байна. -шингэрүүлсэн битум 1 тн 33348 төгрөг байгааг засах, -мяндсан утасны үнэ, орцыг засах -нарны зайн элементээр ажиллах гэрэг нэг багц үнээр орж байгаа тул гэрэлтүүлэгч скэр-500 гэсэн гэрэлтүүлгийн толгойг хасах. Үүний 1ш жин 1тн гэж алдаатай байдшийг анхаар	-1ш явган замын хашлагын үнийг 4460 төг, 1м явган замын хашлагын үнийг 8920 төгрөгөөр тооцов. -Шингэрүүлсэн битум 1 тн 1174500 төгрөг болгон засав. -Өгөгдсөн алдаа зөрчилийг засав.
<p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 9-44 оны сарын өдөр 6613 Биелэлтийн тайлбар бичсэн /Г.Удвал/ 2024 оны 07 сарын 01 өдөр</p>  		

Барилга хот байгуулалтын сайдын
2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ТӨСВИЙН НҮҮР ХУУДАС /ХАВСРАЛТ 17А/

Төсвийн дугаар ТШ-52/2024

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРОО
ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ /79,90 Р ЦЭЦЭРЛЭГ ОРЧИМД/

Төсөвт өртгийн дүн: /тоогоор / 551 861 699 / төгрөг

(Таван зуун тавин нэгэн сая найман зуун жаран нэгэн мянга зургаан зуун ерэн ес)төгрөг

Баталгаажуулсан:

Зураг төслийн "ГИПОТЕНУЗ ДИЗАЙН" ХХК

Захирал

Огноо 2024 он 07 сар 01 өдөр



/ М.Энхтөр/

Хянасан:

Тэргүүлэх төсөвчин:

Огноо 2024 он 07 сар 01 өдөр



/ Г.Оюунтөгс /

Гүйцэтгэсэн:

Мэргэшсэн төсөвчин

Төсөв тооцсон: /огноо/ 2024 он 07 сар 01 өдөр



/Г.Удвал/



Хаяг: УБ хот СХД 16-р хороо 26-187

Цахим хаяг: Bat.udval84@gmail.com

Утас: 99024984, 88056049

ТӨСВИЙН ТОВЧ ТАЙЛБАР

✓ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- ✓ Гүйцэтгэгч байгууллага: **“Гипотенуз дизайн” ХХК**
 - ✓ Компанийн тусгай зөвшөөрлийн дугаар: **ЗТ12-896/21**
 - ✓ Ажлын зургийн нэр, байршил: ГД:26-2024/05 дугаартай, СХД-н 18 дугаар хороо, Гудамж, зам талбайн тохижилт хийх ажил
 - ✓ Төсөвчний нэр хаяг, e-mail хаяг, утас: Ганболдын Удвал, 99024984, Bat.udval84@gmail.com
- Төсвийн тухай тэмдэглэл
- ✓ Барилгын төсвийг боловсруулахад хэрэглэсэн төсвийн норматив, ажлын зургийн жагаалт /ЕТ/ гэсэн зургийн бүрдэлтэй.
 - ✓ Төсвийг БХБЯ 2008.02.13-н өдөр батлагдсан №01 тоот гэрчилгээтэй “ESTIMATOR –PRO” төсвийн программаар, “Гипотенуз дизайн” ХХК-ийн боловсруулсан ГД:26-2024/05 шифртэй СХД-н 18 дугаар хороо гудамж, зам талбайн тохижилт /79,90 р цэцэрлэг орчимд хийх ажлын зурагт өгөгдсөн ажлын тоо хэмжээг үндэслэн зохиов.
 - ✓ Зургийн нэр төрөл, хийц эдлэл, тоног төхөөрөмжийн тухай товч мэдээлэл: **ЕТ**
 - Гадна тохижилт: 2000,23 м2 асфальт бетон хучилттай авто зам, машины зогсоол, 1221,87 м2 өнгөт хавтан хучилттай явган зам талбай, 417,8м2 таримал зүлэг 100ш гоёлын бут ногоон байгууламжтай, 233,69 м2 бетон зам, 35ш 7м өндөртэй нарны эрчим хүчний эх үүсвэртэй гудамжны гэрэл тус тус төлөвлөсөн байна.
 - ✓ Ажлын тоо хэмжээ, материалын түүвэр нь зургаас зөрсөн эсэх:
 - ЗТБХБСайдын 2012 оны 01-р сарын 13-ны өдрийн 18 тоот, БХБС -ны сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 30 тоот тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу
 - Зохиогчийн хяналтын зардлыг БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 185 дугаар тушаалын дагуу
 - Магадлашгүй ажлын зардал, норм нормативын сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцсон болно. Материалын түүвэр ажлын тоо хэмжээг зургийн дагуу тооцсон болно.
 - Цалингийн тарифыг 2021 оны тарифаар тооцов.
 - ✓ Материалын гол нэрийн үнийг БХТөв-с эрхлэн гаргадаг барилгын мэдээлэл эмхэтгэл 2023он /Хсар№06(423)/ оны үнийн лавлах зах зээлийн үнэ ханшаар тооцсон ба Тоног төхөөрөмжийн үнийг “Ургамалын далай” ХХК-н материалаар тооцов.
 - ✓ Төсөвт өртгийн дүн: **551 861 699 төгрөг**
 - ✓ Нийт талбай: **3873,6 м2**
 - ✓ 1м2 талбайд ноогдох өртөг: **142 467 төгрөг**

Тайлбар бичсэн:

Мэргэшсэн төсөвчин:



ТӨСӨВТ ӨРТГИЙН ЗАДАРГАА

Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, гудамж зам талбайн тохижилт/79.90 р цэцэрлэгийн орчимд/						ГД:26-2024/05
Аймаг нийслэл	Улаанбаатар	сум дүүрэг, тосгон	СХД	Хороо/Баг	18	Дүүргийн төсөв
УБ хот	Захиалагч: СХД-н ЗДТГ	УБ	Зураг төслийн төсөвт өртөг	"Гипотенуз дизайн"ХХК	Тайлбар:	Жишиг нэгж хүчин чадал /төг/
	Барилгын үндсэн хийц		Төсөвт өртөг	Барилгын талбай /м2/	Нэгж өртөг /төг/	
1 а/. Гадна тохижилтын ажил:						
ГТ	Авто машины зогсоол хийх		234,772,780	2,000.23	117,373	112,140
ГТ	Ногоон байгууламжийн ажил		38,662,200	417.80	92,538	112,140
ГТ	Явган зам талбай хийх ажил		138,822,655	1,221.87	113,615	87,300
ГТ	Бетон талбай хийх ажил /бетон /		26,431,463	233.70	113,100	119,680
	Хэсгийн дүн		438,689,098	3,873.60		
2 б/. Гэрэлтүүлгийн ажил:						
ТТ	1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч/нарны энергийн эх		94,122,601	35	2,689,217	жишиг үнэлгээ байхгүй
	Хэсгийн дүн		94,122,601			
2 б/. Зураг төслийн үнэ:						
ЗТҮ	Зураг төслийн үнэ		19,050,000			
	Хэсгийн дүн		19,050,000			
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ						
	Төсөвт өртгийн нэгдсэн товчоо					
ГТ	Гадна тохижилтын ажил		438,689,098	1,873.37	234,171	
ГТ	Гэрэлтүүлгийн ажил		94,122,601	5,329.17	17,662	
ЗТҮ	Зураг төслийн үнэ		19,050,000	1	19,050,000	
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:					551,861,699	

Тайлбар: Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, гудамж зам талбайн тохижилт/79.90 р цэцэрлэгийн орчимд/ ажилд, тоног төхөөрөмж бусад зардлыг БХТөв-с эрхлэн гаргадаг барилгын мэдээлэл эмхэтгэл 2023он /Хсар№06(423)/ оны үнийн лавлагаас авав.

Төсвийн задаргаа хийсэн:

Төсөвчин:

тамга



Төсөвчний харилцах гар утасны дугаар: 99024984

Төсвийн эксперт

Хянасан:



ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

Д/Д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Ажиллах хүчний зардал	76,508,146
2	Материал	263,052,717
3	Тээвэр	23,541,374
4	Машин ашиглалт	15,306,775
	Шууд зардлын дүн	378,409,012
5	Нэмэгдэл зардал /61 %/	23,843,568
6	Ашиг / 15%/	60,337,887
	Барилга угсралтын ажлын дүн	462,590,467
7	НӨАТ 10%	46,259,047
8	Нормчлолын сан 0.18%	832,663
	Дүн	509,682,176
9	Захиалагчийн албаны зардал	9,251,809
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19,050,000
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	4,625,905
	Дүн	542,609,890
12	Магадлашгүй ажил 2 %	9,251,809
13	Бусад нэмэлт зардал	0
	Дүн	551,861,699

ӨРТГИЙН ТОВЧОО (БАРИЛГЫН АЖЛЫН ҮЕ ШАТААР)

Д/Д	Барилга угсралтын ажлын үе шатны нэр	Бүгд өртөг	Ажиллах хүчний зардал	Материал	Машин механизм	Тээвэр	Нэмэгдэл зардал	Ашиг
1	Авто машины зогсоол	203,253,880	40,236,703	112,746,919	1,905,597	9,313,619	12,539,665	26,511,376
2	Ногоон байгууламжийн ажил	31,423,305	3,215,201	17,708,925	356,934	5,041,543	1,002,009	4,098,692
3	Явган замын тохижилтын ажил	118,861,406	28,082,487	50,832,071	11,234,096	4,457,255	8,751,835	15,503,662
4	Бетон талбай хийх ажил	23,485,875	1,365,756	13,514,801	1,246,151	3,870,158	425,634	3,063,375
5	Гэрэлтүүлгийн ажил	85,566,001	3,607,999	68,250,000	563,996	858,799	1,124,424	11,160,783
НИЙТ ДҮН:		462,590,467	76,508,146	263,052,717	15,306,775	23,541,374	23,843,568	60,337,887

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

ЯВГАН ЗАМЫН ТОХИЖИЛТЫН АЖИЛ

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)						
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тарифт цалин	Нийт цалин	Бүгд цалин	
01-350-01	Явган замын талбайг бульдозероор тэгшлэх	м2	1221.87	/ 2	/	/ 5212	/	/		
11-010-05	5.6тн -моторт индүүгээр хөрсийг хайрга ба дайрган холимоогоор нягтруулах	м2	1221.87	2.5 / 2	0.12 / 0.1	148.457 / 9	122.1	5680 / 5212	843237 / 636839	1,480,076
25-12-03	Замын хашлага тавих /0.5x0.3x0.15м/	1у/м	747.54	3.1 / 2	0.32 /	241.949 /		6227 / 5212	1506615 /	1,506,615
25-07-20	Явган замын суурийг элс-хайрганы хольцоор хийх 6-200мм	1м3	244.38	3.4 / 2	1 / 1	244.38 / 8	244.3	6459 / 5212	1578450 / 1273709	2,852,159
25-07-22	Явган хүний замын хучилтийг хавтангаар хийх	1м2	1221.87	3.7 / 2	0.26 / 1	319.886 / 87	1221.	6690 / 5212	2140034 / 6368386	8,508,421

Нийт Хүн/цаг:

954.67 / 1588.44

Үндсэн цалин:

14,347,271

Инженер техникийн ажилчдын цалин:

2,439,036

Нэмэгдэл цалин:

5,308,490

Нийт цалин:

22,094,797

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%:

2,982,798

Ажлын багаж, хувцас, хэрэглэл:

3,004,892

Ажиллах хүчний зардал:

28,082,487

БЕТОН ТАЛБАЙ ХИЙХ АЖИЛ

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)					
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тарифт цалин	Нийт цалин	Бүгд цалин
25-04-19	Хөдөлгөөс хамгаалах үе байгуулах /2-р зэргийн хөрсөөр/	1м3	233.7	2.9 / 2	0.17 /	39.111 /	6056 / 5212	236859 /	236,859
25-06-04	Зохист бүрэлдэхүүнтэй элс-хайрган хольцоор хучилт хийх	1м3	46.74	3.3 / 2	0.14 /	6.391 /	6381 / 5212	40782 /	40,782
06-010-04	Явган замын Бетон хучилт хийх 233.7м2 /6-150мм/М-200	м3	35	2.4 / 2	0.76 / 1.49	26.677 / 52.01	5587 / 5212	149044 / 271076	420,121

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

Нийт Хүн/цаг:

72 Илжэнэр, Техникийн ажилчдын

697,699

Нэмэгдэл цалин:

258,172

Нийт цалин:

1,074,552

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%:

145,065

Ажлын багаж, хувцас, хэрэглэл:

146,139

Ажиллах хүчний зардал:

1,365,756

АВТО МАШИНЫ ЗОГСООЛ

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)					
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тарифт цалин	Нийт цалин	Бүгд цалин
01-040-03	Авто замын бродюр суулгах хөрсийг гараар ухах	м3	25.12	2.9 / 2	3.81 /	95.692 /	6056 / 5212	579512 /	579,512
25-12-02	Замын хашлага тавих /1x0.3x0.15м/	1у/м	627.8	3.1 / 2	0.32 /	198.843 /	6227 / 5212	1238196 /	1,238,196
25-06-04	Зохист бүрэлдэхүүнтэй элс-хайрган хольцоор хучилт хийх	1м3	400	3.3 / 2	0.14 /	54.695 /	6381 / 5212	349009 /	349,009
25-06-11	Халуун асфальтбетон хучилтыг гараар байгуулах / жижиг тохижилтын ажилд/ 70мм/ 2000.23м2	1м3	140	3.1 / 2	21.09 /	2953.28 / 6	6227 / 5212	18390112 /	18,390,112

Нийт Хүн/цаг:

3302.52 / 0

Үндсэн цалин:

20,556,829

Инженер техникийн ажилчдын цалин:

3,494,661

Нэмэгдэл цалин:

7,606,027

Нийт цалин:

31,657,516

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%:

4,273,765

Ажлын багаж, хувцас, хэрэглэл:

4,305,422

Ажиллах хүчний зардал:

40,236,703

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)		
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

37-010-05	Зүлэг суулгах талбайг гар аргаар тэгшлэх	м2	417.8	2.0 / 2	0.12 /	51.941 /	5212 / 5212	270716 /	270,716
37-010-06	Зүлэг суулгах талбайд тэг тэнхлэг татах	м2	417.8	2.0 / 2	0.03 /	12.438 /	5212 / 5212	64826 /	64,826
37-100-05	Гар аргаар зүлэг тарих хөрсийг бэлтгэх	м2	417.8	2.0 / 2	0.14 /	58.408 /	5212 / 5212	304425 /	304,425
37-100-09	Таримал зүлэг гараар хийх	м2	417.8	1.2 / 2	0.06 / 0	25.36 / 0.08	4460 / 5212	113108 / 436	113,543
37-020-13	Мод, бут суулгах нүхийг гараар ухах	м3	6.2	2.1 / 2	3.66 / 0.32	22.702 / 2	5306 / 5212	120458 / 10438	130,896
37-090-04	Бут сөөгний суулгацыг 1 эгнээгээр хашаалан тарих /шар хуас/	м	100	2.7 / 2	0.57 / 0.81	57.27 / 81	5868 / 5212	336060 / 422172	758,232

Нийт Хүн/цаг: 228.12 / 83.09 Үндсэн цалин: 1,642,638

Инженер техникийн ажилчдын цалин: 279,248

Нэмэгдэл цалин: 607,776

Нийт цалин: 2,529,663

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%: 341,504

Ажлын багаж, хувцас, хэрэглэл: 344,034

Ажиллах хүчний зардал: 3,215,201

ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)					
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тарифт цалин	Нийт цалин	Бүгд цалин
38-560-04	Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах/нарны энергийн эх үүсвэртэй/	ш	35	3.3 / 2	6.62 / 2	231.7 / 70	6381 / 5212	1478478 / 364840	1,843,318

Нийт Хүн/цаг: 231.7 / 70 Үндсэн цалин: 1,843,318

Инженер техникийн ажилчдын цалин: 313,364

Нэмэгдэл цалин: 682,028

Нийт цалин: 2,838,709

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%: 383,226

Ажлын багаж, хувцас, хэрэглэл: 386,064

Ажиллах хүчний зардал: 3,607,999

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

Бүгд хүн/цаг: 4789.19 / 1793.53 **Бүгд цалин: 39,087,816**

Инженер техникийн ажилчдын цалин: 6,644,929

14,462,492

Нэмэгдэл цалин:

60,195,237

Нийт цалин:

8,126,357

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн 13.5%:

8,186,552

Ажлын багаж, хувцас, хэрэгслэл:

76,508,146

Ажиллах хүчний зардал:

БҮЛЭГ ТУС БҮРИЙН МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

ЯВГАН ЗАМЫН ТОХИЖИЛТЫН АЖИЛ

Шифр	Материалын нэр	Материал				Тээвэр				
		Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
1-4271	Ус	М3	1818	26.837	48,789	26.837	1	1	960.47	25,776
1-4542	Уулын элс	М3	22000	63.983	1,407,635	95.975	15	1	334.65	481,771
1-0517	Төмөр гадас d13мм х500мм	Ш	334	268.359	89,632	0.364	15	2	444.24	2,425
1-4334	Хайрга	М3	21276	26.071	554,681	45.624	15	1	334.65	229,020
1-4025	Цемент м-400	ТН	374242	26.435	9,892,943	26.963	15	1	334.65	135,349
1-4292	Явган замын хавтан	М2	22620	1221.87	27,638,699	93.888	15	1	334.65	471,297
1-4542	Голын элс	М3	24500	16.268	398,558	26.842	10	1	348.9	93,651
2-1989	Замын бетон хашлага /0,5x0.3x0.15м/	М	8920	747.54	6,668,057	26.911	15	3	591.18	238,643
1-4032	Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц	М3	16500	250.489	4,133,077	425.832	20	1	323.62	2,756,156

Хог, хаягдлын зардал: 4.6154

15

1

23,168

50,832,071

4,457,255

БЕТОН ТАЛБАЙ ХИЙХ АЖИЛ

Шифр	Материалын нэр	Материал				Тээвэр				
		Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
1-4271	Ус	М3	1818	26.252	47,726	29.087	1	1	960.47	34,726
1-0517	Төмөр гадас	Ш	334	0.42	140	0.000	15	2	444.24	1
6-025	Төмөр гадас d20мм х500мм	Ш	100	3.371	337	0.103	15	2	444.24	685
3-029	Хөлдөлтөөс хамгаалах үеийн материал	М3	4500	245.385	1,104,233	452.613	15	2	444.24	3,016,030
1-4180	Бетон зуурмаг м-200	М3	287500	35.7	10,263,750	85.68	0	1	0	0
1-3982	Захалсан банз	М3	575000	2.275	1,308,125	1.479	15	1	334.65	7,423
1-4032	Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц	М3	16500	47.908	790,490	92.032	20	2	429.95	791,385

Хог, хаягдлын зардал: 3.966

15

1

19,908

13,514,801

3,870,158

БҮЛЭГ ТУС БҮРИЙН МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

АВТО МАШИНЫ ЗОГСООЛ

Шифр	Материалын нэр	Материал				Тээвэр				
		Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
1-4271	Ус	М3	1818	6.697	12,175	6.697	1	1	960.47	6,432
1-4542	Уулын элс	М3	22000	18.353	403,775	27.53	15	1	334.65	138,194
1-0517	Төмөр гадас d13мм х500мм	Ш	334	65.291	21,807	0.089	15	2	444.24	590
6-025	Төмөр гадас d20мм х500мм	Ш	100	28.852	2,885	0.88	15	2	444.24	5,866
1-4025	Цемент м-400	ТН	374242	4.832	1,808,200	4.928	15	1	334.65	24,739
1-0360	Шингэрүүлсэн битум	ТН	1174500	4.242	4,982,229	5.133	15	2	444.24	34,203
1-4180	Бетон зуурмаг м-200	М3	287500	25.489	7,327,995	61.173	0	1	0	0
2-1989	Замын бетон хашлага /1x0.3x0.15м/	М	22770	627.8	14,295,006	69.058	15	3	591.18	612,386
1-4032	Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц	М3	16500	410	6,765,000	787.61	20	2	429.95	6,772,658
1-4198	Жижиг ширхэглэлтэй асфальт бетон хольц	ТН	230000	334.485	76,931,596	334.485	15	1	334.65	1,679,032
3-2701	Мяндсан утас	М	300	654.168	196,250	0.065	15	2	444.24	436

Хог, хаягдлын зардал: 7.7859

15 1 334.65 39,083

112,746,919

9,313,619

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ

Шифр	Материалын нэр	Материал				Тээвэр				
		Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
1-4271	Ус	М3	1818	48.08	87,409	48.08	1	1	960.47	46,179
1-4333	Хар шороо	М3	15000	418.137	6,272,059	585.392	15	1	334.65	2,938,522
1-4604	Шар хуас	Ш	15000	300	4,500,000	78	15	2	444.24	519,761
1-4542	Элс	КГ	23000	5	115,000	7.5	10	1	348.9	26,168
1-4034	Бууц	М3	3000	100.112	300,337	120.135	15	1	334.65	603,046
1-4542	Голын элс	КГ	24500	167.12	4,094,440	250.68	10	1	348.9	874,623
1-4275	Зүлэгний суулгацын үр	КГ	28000	83.56	2,339,680	0.084	15	1	334.65	419

Хог, хаягдлын зардал: 6.5392

15 1 334.65 32,825

17,708,925

5,041,543

БҮЛЭГ ТУС БҮРИЙН МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

Шифр	Материалын нэр	Х/Н			Материал		Тээвэр			
		Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
3-3815	1 толгойтой төмөр багана 6000h / 400w./	ком	1950000	35	68,250,000	2.1	1457	2	280.66	858,735

Хог, хаягдлын зардал: 0.0126 15 1 334.65 63
68,250,000 **858,799**

Хог, хаягдлын зардал: 22.9191 15 1 334.65 115,048
263,052,717 **23,541,374**

НИЙТ ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ДҮН:

МАШИН МЕХАНИЗМЫН ХЭРЭГЦЭЭ (ҮЕ ШАТААР)

ЯВГАН ЗАМЫН ТОХИЖИЛТЫН АЖ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
9013	Хийн цохилтот нягтруулагч	283.47	35460	10,051,982
1002	Экскатор 1м3	3.85	53566	206,175
2028	Автокран 5тн	3.54	59489	210,795
	Автомашин	1.39	13800	19,222
05*04	Доргиурт хосолмол булт индүү 10-12тн	11.69	63789	745,922

11,234,096

БЕТОН ТАЛБАЙ ХИЙХ АЖИЛ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
04*01	Усны машин	2.22	13800	30,703
01*01	Экскаватор	8.83	23181	204,778
7021	Бетон зуурмагийн насос	10.08	58483	589,509
7005	Авто бетон зуурагч	10.08	17364	175,029
03*01	Автогрейдер	1.97	33960	66,825
	Автомашин	0.01	13800	77
05*03	Доргиурт хосолмол булт индүү	6.3	24800	156,196
53*01	Пикап	5.12	4500	23,035

1,246,151

АВТО МАШИНЫ ЗОГСООЛ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
04*01	Усны машин	0.17	13800	2,376
06*04	Хийн дугуйт индүү 14-16тн	11.2	30459	341,141
90*02	Хүнд гөлгөр булт индүү	5.15	58930	303,607
03*01	Автогрейдер	0.64	33960	21,734
13*	Гар гудорнатор	7	87169	610,183
54*03	Гөлгөр булт индүү	10.22	54452	556,499
53*01	Пикап	15.57	4500	70,056

1,905,597

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
2028	Автокран 5тн	6	59489	356,934

356,934

ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
2144	Шаттай машин	32.2	10224	329,213
2028	Автокран 5тн	0.02	59489	1,249
3033	Гагнуурын аппарат	12.25	19064	233,534

563,996

НИЙТ ДҮН:

15,306,775